



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/1/28

Номгон

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн
байдлын зэрэгт шилжсэн үед авч хэрэгжүүлэх
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “б”, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2021 оны 176 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны А/342, А/426 дугаар захирамж, аймгийн Онцгой комиссын 2021 оны 55 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдварын тархалтыг бууруулах, тогтоох, хяналтад авах зорилгоор аймгийн хэмжээнд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх хорио цээрийн дэглэм тогтоосон хугацааг 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 00:00 цагаас 2021 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 24:00 хүртэл 10 хоногоор сунгасугай.

2.Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосонтой холбогдуулан үйл ажиллагаа явуулах зөвшөөрөгдсөн салбар, байгууллагуудын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3.Дээрх хугацаанд “Нэг өрх-Нэг шинжилгээ” нэгдсэн арга хэмжээг үргэлжлүүлэн, эрчимжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал)-т;

4.Хяналтын постуудын үйл ажиллагааг эрчимжүүлж, зохион байгуулалтын шуурхай арга хэмжээг авч ажиллахыг аймгийн Онцгой комиссын Шуурхай штаб (дэд хурандаа Э.Батбаяр)-т;

5.Тус аймгийн Баянхонгор сумын 3, 6, 9 дүгээр багуудын нутаг дэвсгэрт үүссэн үерийн усны халианы бохирдол болон коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх нэгдсэн ариутгал халдваргүйжүүлэлтийг 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хооронд зохион байгуулж иргэд, олон нийтийг болзошгүй халдварт өвчний эрсдэлээс хамгаалахыг Мэргэжлийн хяналтын газар (Н.Бямбадорж)-т;

621011085

6.Тус аймгийн хэмжээнд рашаан сувилал, амралт, жуулчны баазын үйл ажиллагааг нээсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” А/291 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангуулж, халдвар, хамгааллын дэглэмийг мөрдүүлэх хяналт шалгалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран өдөр бүр зохион байгуулж дүнг аймгийн Онцгой комисст танилцуулж ажиллахыг;

7.Тус аймаг руу орох, гарах зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарласантай холбогдуулан тус аймгаас Улаанбаатар хот болон бусад аймаг руу эрүүл мэнд, буяны ажил, хүнс, шатахуун тээвэр, эм эмнэлгийн хэрэгсэл татан авах, хойшлуулшгүй албан томилолтын ажлаар зорчих (орох, гарах) иргэдийг аймгийн Онцгой комиссын зөвшөөрлийн бичгийг үндэслэн тус тус нэвтрүүлэх, шаардлагагүй тохиолдолд Улаанбаатар хот болон халдварын тархалтын “Шар”, “Улбар шар”, “Улаан” түвшин бүхий аймгуудаас иргэдийг татан авахгүй байхыг Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Оюутболд)-т тус тус үүрэг болгосугай.

8.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, аймгийн Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг дарга 2021 оны
07 дугаар сарын 05-ны өдрийн
А/428 дугаар захирамжийн
хавсралт

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ЗӨВШӨӨРӨГДСӨН САЛБАР,
БАЙГУУЛЛАГУУДЫН ЖАГСААЛТ

1. Эрчим хүч, дулаан, усан хангамж;
2. Эрүүл мэндийн байгууллага, эмийн сан, эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага;
3. Шатахуун, түлшний худалдаа, тээвэрлэлт;
4. Хүнсний худалдаа, тээвэрлэлт, түгээлт, ханган нийлүүлэлт (хүнсний дэлгүүрүүд 10:00-20:00 цаг);
5. Ариутгал, халдваргүйжүүлэлт, хог хаягдлын цэвэрлэгээ, ачилт, тээвэрлэлт;
6. Банкууд цахимаар болон ажлын тусгай горимоор халдвар хамгааллын дэглэм сахиж ажлын өдрүүдэд тусгай горимоор (30 хувь нь ажлын байранд, 70 хувь нь цахимаар);
7. Харилцаа холбоо, хэвлэл мэдээлэл, шуудан илгээмж;
8. Хууль тогтоох, төрийн захиргааны байгууллага, төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага, шүүх, прокурор, иргэдэд үйлчилгээ үзүүлдэг нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагаа тусгай горимоор (30 хувь нь ажлын байранд, 70 хувь нь цахимаар);
9. Улсын онц чухал болон стратегийн ач холбогдол бүхий объект, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаа;
10. Тусгай зөвшөөрөлтэй харуул хамгаалалтын байгууллагын үйл ажиллагаа;
11. Жижиг дунд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа;
12. Уул уурхайн ээлж солилцох үйл ажиллагаа (Бусад хангамж);
13. Газар тариалангийн үйл ажиллагаа;
14. Барилгын үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, тээвэрлэлт,
15. Буян номын үйл ажиллагаа;
16. Рашаан сувиллын үйл ажиллагааг тусгай нөхцөл шаардлагыг хангасан тохиолдолд үйл ажиллагааг нээх;
17. Амралт, жуулчны бааз зөвхөн гэр бүлээрээ явж байгаа иргэдэд үйлчлэх бөгөөд архи согтууруулах ундааны зүйлээр үйлчлэхгүй байх.

-----oOo-----